

Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани



**МОНГОЛ
ШУУДАН**



**МОНГОЛ
ШУУДАН**

2017 он

**ЖИЛИЙН
ТАЙЛАН**



**МОНГОЛ
ШУУДАН**

Агуулга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4-5
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл	6-7
Түүхэн замнал, 97 жилийн түүхтэй брэнд	8-9
Үйлчилгээний танилцуулга	10-13
2017 оны марк	14-17
2017 оны зорилго, зорилт, үйл ажиллагаанууд	18-31
Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд	32-38
Шуудангийн салбарын зах зээлийн танилцуулга	39-41
2017 оны гүйцэтгэлийн тайлан	42-43
Аудитын тайлан	44-49



“Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Б.АНХБААТАР

Мэндчилгээ

Эрхэм хүндэт харилцагчид, бизнесийн түншүүд, хувьцаа эзэмшигчид болон компанийн нийт шууданчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Өдөр бүр уулзах, үндэсний шийлдэг компани” болох алсын хараатай “Монгол шуудан” ХК-ийн хамт олон бид түүхэн хөгжлийнхөө замналд эх орныхоо эдийн засгийн өсөлт, харилцаа холбооны салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж, та бүхний найдвартай хамтрагч нь байсаар ирлээ.

Тус компани нь стратеги зорилгуудын хүрээнд дэвшүүлсэн бизнес төлөвлөгөөний зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж, бизнесийн цар хүрээ, үйл ажиллагаагаа өргөжүүлж, хөгжлийн шинэ шатанд хүрэхийн төлөө чармайн ажиллаж байна.

Бид цаашид “Мэргэжлийн хүртээмжтэй үйлчилгээгээр дамжуулан нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах” эрхэм зорилгоо хэрэгжүүлж, харилцагчдад орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан чанартай, хүртээмжтэй бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэн, хувь нийлүүлэгчдийн үр ашгийг нэмэгдүүлсэн үндэсний шилдэг компани байх болно.

Бидэнд итгэл хүлээлгэн ажилладаг Төлөөлөн удирдах зөвлөл, сэтгэл зүрхээ зориулан ажилладаг шууданчиддаа талархал илэрхийлж, нийт харилцагчид, бизнесийн түншүүд, хувьцаа эзэмшигч та бүхний цаашдын ажил үйлсэд тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Д.НАРАНГЭРЭЛ

ТУЗ-ийн дарга
ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн



Д.ДЭЛГЭРМАА

ТУЗ-ийн гишүүн
ТӨБЗГ-ын мэргэжилтэн




Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

ТУЗ-ийн гишүүн
ЗГХЭГ-ын референт



О.ОДБАЯР

ТУЗ-ийн гишүүн
“Эрдэнэс монгол” ХХК-ийн
дэд захирал



**С.МӨНГӨНЦЭЦЭГ**

ТУЗ-ийн гишүүн
СЯ-ны ТЗУГ-ын СЗБХ-ийн дарга

**Ч.ГАНХУЯГ**

ТУЗ-ийн гишүүн
Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн
гүйцэтгэх захирал

**М.ХАЛИУНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн
“Монгол Айдия” группийн
гүйцэтгэх захирал

**Б.АМАРСАНАА**

ТУЗ-ийн хараат бус гишүүн
“МПЭ” ХХК-ийн гүйцэтгэх захирал

**Ч.ЧИНЗОРИГ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн
“Азума шиппинг Монголиа”
компанийн захирал

ТҮҮХЭН ЗАМНАЛ

Эрхэм зорилго

МЭРГЭЖЛИЙН, ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ НИЙГЭМ

БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ, ТАНИЛЦУУЛГА

Шуудан харилцаа нь манайд Хүннү гүрний үеэс, он цагийг илүү наашлуулбал их эзэн Чингис хааны хүү Өгөөдэй хааны дөрвөн сайн үйлийн нэг болох сайтар зохион байгуулсан өртөөт зам “Монголын морин өртөө”-нөөс үүсэлтэй гэж үздэг.

Тиймээс ч Монголын шуудан, харилцаа холбоо нь үүсэл хөгжлөөрөө дэлхийн шуудан холбооны түүхэнд анхдагч болж, тэргүүн эгнээнд жагсдаг юм. Тэгвэл өнө эртний түүхт эл салбарт үйл ажиллагаагаа 96 жил тасралтгүй явуулж, ололт амжилтын туршлагыг хуримтлуулсан “Монгол шуудан” компанийн хөгжлийн түүх 1921 оноос эхлэлтэй. Удахгүй 100 нас хүрэх компани алдаа оноотой он жилүүдийг ардаа үдсэн ч Монгол улсынхаа харилцаа холбооны салбарыг нуруундаа үүрсээр өнөөг хүрсэн.

Монгол улс дэлхий дээр өргөн уудам нутгийг эзлэн оршиж байх үед буюу 1228-1241 онд Монголын эзэнт гүрний их хаан Чингисийн гуравдугаар хөвгүүн Өгөөдэй морин өртөө

байгуулснаар мэдээлэл дамжуулах сүлжээг анх үүсгэсэн юм. Өртөө нь он цагийн уртад улам боловсронгуй болж хөгжсөөр, Ардын хувьсгал мандсан 1921 оны долдугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн VI хурлын тогтоолоор “Монгол Улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо” байгуулсан нь одоогийн “Монгол шуудан” ХК юм. Монгол Улсын шуудангийн үндсэн сүлжээг эзэмшигч “Монгол шуудан” ХК нь Улаанбаатар хотын 40 салбар, аймаг орон нутгийн 22 шуудангийн үйлчилгээний газар, сумдын 330 гаруй салбар нэгжээр, 909 ажилчинтайгаар шуудангийн 20 гаруй нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэн явуулж байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ

Алсын хараа:

“ӨДӨР БҮР УУЛЗАХ ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ КОМПАНИ”

Өнөөдрийн байдлаар:

 Дэлхийн **192** улсад **Москва, Бээжин, Гонконг, Токио, Сөүл, Истанбул** хотуудаар дамжуулан
 7 хоногт 3-6 удаа агаараар,  Монгол улсын нутаг дэвсгэрт Улаанбаатараас аймгийн төвүүдэд
 7 хоногт 4-6 удаа агаараар болон  |  газраар, Аймгийн төвөөс сумдад 7 хоногт 1–3 удаа газраар
 шуудан хүргэж байна. 2017 онд улсын хэмжээнд  **28 700** шуудангийн уламжлалт болон ухаалаг
 хайрцгаар ард иргэд, албан байгууллагуудад үйлчилж,  **200 000** гаруй иргэн, албан байгууллагад
 захиалгат хэвлэлийг хүргэж,  **10 000** орчим байгууллагад шуудангийн үйлчилгээг гэрээлэн хүргэж,
 **10 000 000** ширхэг бичиг захидал, боодол, илгээлт, хэвлэлийг



ХАЯГТ ЭЗЭНД нь хүргэж гардуулжээ.





**УЛС ХООРОНДЫН
ШУУДАНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ**

**ТА ДЭЛХИЙН 192 ОРОНД
АЖИЛЛАЖ АМЬДАРЧ БУЙ ААВ,
ЭЭЖ, АХ, ЭГЧ, ДҮҮ, НАЙЗ НӨХӨД,
БИЗНЕСИЙН ХАМТРАГЧИДДАА БИЧИГ
ЗАХИДАЛ, ИЛГЭЭЛТЭЭР АЛБАН БИЧИГ,
БЭЛЭГ ДУРСГАЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗҮЙЛСИЙГ ХЯМД ҮНЭЭР ИЛГЭЭХ
БОЛОМЖТОЙ.**



БИЧИГ ЗАХИДАЛ, БООДОЛ

Иргэд, албан байгууллагаас бусдад илгээх бичиг захидал, боодол, эд зүйлс, албан бичгийг энгийн, бүртгэлтэй, даатгалтай хэлбэрээр хүлээн авч, Монгол улсын нутаг дэвсгэрт заасан хаягаар тогтоосон хяналтын хугацаанд болон шуурхай хүргэж гардуулдаг ба бусад улсад хамтран ажилладаг шуудангийн байгууллагуудаар хүргүүлдэг.



ИЛГЭЭЛТ

Иргэд, албан байгууллагаас бусдад илгээх эд зүйлс, бараа материалыг бүртгэлтэй, даатгалтай хэлбэрээр хүлээн авч, Монгол улсын нутаг дэвсгэрт заасан хаягаар тогтоосон хяналтын хугацаанд болон шуурхай хүргэж гардуулдаг ба бусад улсад хамтран ажилладаг шуудангийн байгууллагуудаар хүргүүлдэг.



БУУХИА ШУУДАН

Монгол улсын нутаг дэвсгэрт шуудангийн илгээмжийг хотын дотор болон хотуудын хооронд, мөн дэлхийн **116** улсад хамгийн богино замаар, хурдан шуурхай хүргэж гардуулах үйлчилгээ.



МАРК, ИЛ ЗАХИДЛЫН ХУДАЛДАА

Марк, ил захидлын эх загвар, дизайныг судалгааны үндсэн дээр зохион бүтээх, хэвлүүлэх, борлуулах үйлчилгээ ба өнөөдрийн байдлаар худалдаанд **1029** нэрт төрлийн марк, **4090** нэр төрлийн ил захидал борлуулагдаж байна.



ШУУДАНГИЙН УЛАМЖЛАЛТ БОЛОН УХААЛАГ ХАЙРЦАГ

Хэрэглэгчдэд шуудангийн салбарын хайрцгийг түрээсээр эзэмшүүлснээр хэрэглэгч албан ёсны тогтмол хаягтай болох ба бүх төрлийн шуудангийн илгээмж, хэвлэлээ хүссэн цагтаа хүлээн авах боломжтой. Улаанбаатар хотын төв шууданд илгээмж ирсэнийг хэрэглэгчид мэдээлэх, илгээмж гардуулагдсаныг хянах цогц шийдэл бүхий ухаалаг шуудангийн хайрцаг, улсын хэмжээнд **28600** ширхэг уламжлалт шуудангийн хайрцаг үйлчилж байна.



ДОТООД, ГАДААД ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА

Дотоодын өдөр тутмын, чөлөөтболон орон нутгийн **294** төрлийн хэвлэл сэтгүүл, **2000** гаруй нэр төрлийн ном, Англи хэл дээр дэлхийн **50** гаруй шилдэг сэтгүүл, Орос хэл дээр **400** төрлийн сонин хэвлэл, сэтгүүлийг захиалан хүргүүлэх боломжтой.

БУУХИА ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЭРЭГЛЭГЧИЙН ИЛГЭЭЖ БУЙ БИЧИГ БАРИМТ, БЭЛЭГ
ДУРСГАЛ, ЭД ЗҮЙЛСИЙГ ХАЯГТ ЭЗЭНД НЬ ХАМГИЙН БОГИНО
ЗАМААР, ХУРДАН ШУУРХАЙ, "ГАРААС ГАРТ" ХҮРГЭЖ
ГАРДУУЛДАГ ҮЙЛЧИЛГЭЭ ЮМ.



УЛС ХООРОНДЫН БУУХИА ШУУДАН EMS:

7 ХОНОГ ТУТАМД **8 САЯ** ИЛГЭЭМЖ
СОЛИЛЦОЖ БАЙДАГ, ДЭЛХИЙН 181
УЛСАД САЛБАР БҮХИЙ ДЭЛХИЙН
ШУУДАНГИЙН ХОЛБООНЫ
БРЭНД ҮЙЛЧИЛГЭЭ



ДОТООДЫН БУУХИА ШУУДАН EMS:

УЛААНБААТАР ХОТОД БОЛОН
ХОТ, АЙМГИЙН ТӨВИЙН ХООРОНД
ХЭРЭГЛЭГЧИЙН ИЛГЭЭСЭН ЗҮЙЛСИЙГ 360
ШУУДАНГИЙН САЛБАРААР ДАМЖУУЛАН
ШУУРХАЙ ХҮРГЭХ ҮЙЛЧИЛГЭЭ



ХҮРГЭЛТ

Таны захиалсан (сунгуулсан) гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, банкны дебит болон кредит карт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, мөн үүрэн телефоны хэрэглэгчийн нэхэмжлэл, замын хөдөлгөөний торгуулийн хуудсыг хаягаар хүргэж гардуулах үйлчилгээ юм. Түүнчлэн авто замын эхлэл **0 цэгээс 1 км-ийн радиуст "А бүс"**-ийн шуудангийн шуурхай хүргэлт хийлгэж болох ба "Бизнес захидал"-аар зорилтот хэрэглэгч, бизнесийн хамтрагчиддаа өөрийн бизнесийн танилцуулга, саналаа хүргүүлэх, захиалгат хэвлэлээ өглөөний **04-09** цагийн хооронд **"Эртийн хүргэлт"**-ээр хүргүүлэн авах боломжтой.



POST SHOP

Бичиг хэргийн зүйлс, ном, бэлэг дурсгал, шуудангийн хэрэглэгдэхүүний худалдаа.



ГИБРИД ШУУДАН

Цахим сүлжээгээр илгээсэн үүрэн телефоны хэрэглэгчийн нэхэмжлэл, шүүхийн мэдэгдэх хуудас, хурлын тов, татварын өрийн бичиг, мэдэгдэх хуудсыг хүлээн авч, цахим орчинд ялган боловсруулж гардуулах шуудангийн салбарт илгээх ба шуудангийн салбар тэдгээрийг хэвлэн битүүмжилж хаягаар хүргэж гардуулах үйлчилгээ.



ЦАХИМ ХУДАЛДАА

www.mongolstamps.com,
www.postnews.mn цахим хуудсаар дамжуулан дэлхийн хаанаас ч монгол маркийг худалдаж авах, хэвлэл сэтгүүлээ захиалан хүргүүлэх боломжтой.



ШУУДАНГИЙН АЧАА ТЭЭВЭР, ТЭЭШ

Замын үүд – Улаанбаатар – Замын үүд чиглэлд иргэдийн ачааг тээвэрлэн хүргэх үйлчилгээ бөгөөд энэ нь **Дүнжингарав худалдааны төвийн дэргэдэх Шуудангийн 56-р салбарт**, зорчигчийн тээшийг түр хадгалах үйлчилгээ нь **Драгон ба Тэнгэр худалдааны төвүүд дэх шуудан солилцох цэгүүдэд** боломжтой.



ШУУД СУРТАЛЧИЛГАА/ ДИРЕКТ ШУУДАН

Зар сурталчилгааны материалыг хэвлэл захиалагчид болон шуудангийн хайрцаг эзэмшигчдэд, зорилтот хэрэглэгчдэд хямд зардлаар, гарт нь, хүртээмжтэй байдлаар түгээх үйлчилгээ.



МАРК НЬ:



Фото зургийг Х.Түшиг

УЛС ОРНЫ ТУСГААР ТОГТНОЛЫН БЭЛГЭ ТЭМДЭГ,
УРЛАГИЙН БҮТЭЭЛ,
СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ,
ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН БАРИМТ,
ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДАЛ,
БАЙГАЛЬ, АН АМЬТАН,
ЁС ЗАНШЛЫГ СУРТАЛЧЛАХ
СУРТАЛЧИЛГААНЫ ХЭРЭГСЭЛ ЮМ.

МАРК



Монгол Улсын шуудангийн анхны марк нь 1924 онд хэвлэгдэж байжээ. Тодруулбал, 1924 оны долдугаар сарын 1-нд 1, 2, 5, 10, 20, 50 цент болон 1 ам.долларын нэрлэсэн үнэтэй, таван өнгө ялгасан нэгэн багц маркийг хэвлүүлж гаргасан тухай Цахилгаан шуудангийн ерөнхий хороо, Гадаад явдлын яамнаас 1924 оны наймдугаар сарын 2-ны өдөр Засгийн газарт өргөн барьсан 42/565 тоот албан бичигт дурдсан байдаг.

МАРКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

“Монгол шуудан” ХК-ийн хөгжил дэвшилтэй “марк” зайлшгүй холбогддог. Марк бол шуудангийн үйлчилгээний үндсэн бүтээгдэхүүн юм. Монголын шуудан холбоо нь олон зуун жилийн түүхийг бүтээсэн боловч Ардын хувьсгал ялах хүртэл буюу 1924 он хүртэл өөрийн үндэсний маркгүй байжээ.

Харин 1924 онд анхны маркаа худалдаанд гаргаснаас хойш олон төрлийн марк бүтээж, эдгээр нь “Монгол шуудан”-гийн бүтээгдэхүүн болсоор ирсэн юм. Анхны марк гарснаас хойш 2017 оныг хүртэл 1029 гаруй сэдвийн 4090 гаруй нэр төрлийн марк худалдаанд гаргажээ.

2017 ОНЫ МАРК



КОД 1019 Сэдвийн нэр: ТАХИА ЖИЛ

Маркийн нэр төрөл: 2 номинал
Анхны өдөр: 2017.01.08



КОД 1020 Сэдвийн нэр: ЕСӨН ЭРДЭНЭ

Маркийн нэр төрөл: Хэлхээ 1-9н
Анхны өдөр: 2017.04.30

Нүүрний үнэ:
Алт Шүр Оюу
Мөнгө Сүвд Ган
Тана Номин Зэс



КОД 1021 Сэдвийн нэр: ГАЛТ ТЭРЭГНИЙ ЗҮТГҮҮР

Маркийн нэр төрөл: Хэлхээ 1-6н
Анхны өдөр: 2017.06.16

ТЭ2 ТЭМ 2
2ТЭ116УМ М62УМ
2 ZAGAL DASH 7



КОД 1022
1023 Сэдвийн нэр: ШАР ШУВУУ

Маркийн нэр төрөл: 4н, хэлхээ 1-4н
Анхны өдөр: 2017.07.06

Эгэл шар шувуу Угалзан ууль
Харсуун бэгбаатар, Цагаан ууль



КОД 1024 Сэдвийн нэр: МОНГОЛ ЭМЭЭЛ

Маркийн нэр төрөл: 4 номинал
Анхны өдөр: 2017.08.27

VIII зуун XIII зуун
XIX зуун XX зуун



КОД 1025

Сэдвийн нэр:
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН
НИЙТИЙН ТЕЛЕВИЗИЙН 50
ЖИЛИЙН ОЙ

Маркийн нэр төрөл: 1 номинал
Анхны өдөр: 2017.09.08



КОД 1026


Сэдвийн нэр:
“МОНГОЛ УЛСАД МЭДЭЭЛЭЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭЭД
БОЛОВСРОЛТОЙ МЭРГЭЖИЛТЭН
БЭЛТГЭСНИЙ 50 ЖИЛ”

Маркийн нэр төрөл: 1 номинал
Анхны өдөр: 2017.10.06



КОД 1027 Сэдвийн нэр: МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БАХАРХАЛТ БЭР ЦЭЦЭГ

Маркийн нэр төрөл: Хэлхээ 1-2н
Анхны өдөр: 2017.11.15



КОД 1028 Сэдвийн нэр: ТОРГОНЫ ЗАМЫН ЗООС

Маркийн нэр төрөл: 1 блок
Анхны өдөр: 2017.12.03



КОД 1029

Сэдвийн нэр: ШИНЭ ЖИЛИЙН
МЭНД ХҮРГЭЭ!

Маркийн нэр төрөл: 1 номинал
Анхны өдөр: 2017.12.08



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2017 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол шуудан компанийн 2017 оны зорилго

- Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх замаар шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, шуудангийн байгууллагын шинэ өнгө төрхийг тодорхойлж орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөх
- Дотоодын болон Олон улсын тээвэр зууч, транзит тээвэр, логистикийн үйлчилгээг эхлүүлэх
- Шуудангийн үндсэн сүлжээг ашиглан Санхүүгийн нэгдсэн үйлчилгээг эхлүүлэх

Монгол шуудан компанийн 2017 оны зорилтууд

I ҮНДСЭН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

- Компанийн зах зээлд эзлэх байр суурь нэр хүндийг өсгөх замаар Шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх
- Шуудангийн салбар нэгжүүдийн байршил, хамрах хүрээг оновчтой болгох
- Шуудан хүргэлтийн шинэ технологийг нэвтрүүлэх
- Шуудангийн салбар нэгжүүдийн өнгө төрхийг тодорхойлон бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх Ребрэндингийн ажлыг хийх
- Шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ тарифийг боловсронгуй болгох
- Шуудангийн ажилчдын болон харилцагч байгууллагуудад олгох урамшууллын системийг бий болгох
- Хөдөө орон нутгийн шуудангийн салбаруудын шуудан хүргэлтийн өртөгийг бууруулах, алдагдлыг багасгах
- Шуудангийн стандартын шаардлагын хангасан, зах зээлийн боломжуудыг цогцоор шийдвэрлэсэн нэгдсэн гуулахыг бариж байгуулах

II ҮНДСЭН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

- Олон улсын болон дотоодын логистик, тээвэр зуучын үйлчилгээг нэвтрүүлэх дэд бүтцийн болон технологийн шийдлүүдийг тодорхойлох, шийдвэрлэх
- Олон улсын транзит шуудангийн үйлчилгээг өргөжүүлэх, хөгжүүлэх
- Дотоод логистик тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх
- Дотоод логистик тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэх, бүх аймгийн төвүүдэд логистик үйлчилгээг эхлүүлэх
- Гаалийн бүрдүүлэлт хийх мэргэжилтэн бэлдэх, бүрдүүлэлт хийж Олон улсын тээвэр зуучын үйлчилгээг эхлүүлэх

III ҮНДСЭН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

- Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчныг тодорхой болгох ажлын хэсэг байгуулж, тодорхойлох
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран шуудангийн үндсэн үйлчилгээгээр дамжуулж санхүүгийн үйлчилгээ үзүүлэх



“Монгол шуудан” ХК нь 2017 онд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх замаар шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, шуудангийн байгууллагын шинэ өнгө төрхийг тодорхойлж, орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөх, дотоодын болон олон улсын тээвэр зууч, транзит тээвэр, логистикийн үйлчилгээг эхлүүлэх, шуудангийн үндсэн сүлжээг ашиглан, санхүүгийн нэгдсэн үйлчилгээг эхлүүлэх гэсэн зорилтуудыг дэвшүүлэн дараах чиглэлийн хүрээнд ажиллалаа.

2017 ОНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН



01 сарын 09



“Тахиа жил” сэдэвт шуудангийн марк худалдаанд гарав

01 сарын 17



Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээг шинэчлэн батлав.

01 сарын 25



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал боллоо.

01 сарын 08



Албан хэрэг хөтлөлтийн журмыг шинэчлэн батлав.

01 сарын 21



Шуудангийн удирдах ажилтны зөвлөлгөөнийг зохион байгуулав.

03 сарын 01



Хэвлэл захиалгыг онлайнгаар авч эхэллээ.

03 сарын 24



Хас банкны төлбөрийн картыг шуудангаар хүргэх үйлчилгээг нэвтрүүлэв.

04 сарын 05



Буухиа шууданг 116 улстай солилцож эхлэв.

04 сарын 10



“Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага 2017” өдөрлөгт амжилттай оролцож, тус өдөрлөгийн **шилдэг байгууллагаар** шалгарлаа.

04 сарын 14



“Монголын” **Топ-100 аж ахуйн нэгж**-ийн нэгээр шалгарав.

04 сарын 22



“Хөрөнгө оруулагч үндэстэн” чуулга уулзалтанд амжилттай оролцож **TURNAROUND OF THE YEAR** шагнал хүртлээ.

05 сарын 30



Салбарын СПОРТ наадамд амжилттай оролцож байгууллагын дүнгээр мөнгөн цом авлаа.

06 сарын 06



Засгийн газрын хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг олон нийтэд сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгт амжилттай оролцлоо.

06 сарын 12



Авто тээврийн үндэсгий төвтэй хамтран, Драгон буюу баруун автовокзал дээр “Тээшийн үйлчилгээний төв”-ийг шинээр байгуулж, албан ёсны нээлтээ хийлээ.

06 сарын 10



Улаанбаатар хотын ажилтнуудыг аттестатчиллах ажлыг зохион байгууллаа.

06 сарын 16



“Галт тэрэгний зүтгүүр” сэдэвт марк худалдаанд гарлаа.

07 сарын 06



Улс хоорондын транзит үйлчилгээг шинэ шатанд хөгжүүлэх, шинэ харилцагчтай гэрээ байгуулав.

08 сарын 11



“Монгол шуудан” ХК-ийн **ЛОГО** шинэчлэгдлээ.

08 сарын 15



Шуудангийн логистик үйлчилгээнд том оврын автомашин явуулж эхлэв.

08 сарын 27



“Монгол эмээл” сэдэвт шуудангийн марк худалдаанд гаргав.





Шинэ марк худалдаанд гарав.



Шагнал авав.



Тохиролцоонд хүрэв. Шинэчлэн батлав. Гэрээ хийв.



Хурал, нээлт, үйл ажиллагаа зохион байгуулав.

09 сарын 06



Санхүүгийн посын систем нэвтрүүлж, зураасан код ашиглаж эхэллээ.

09 сарын 08



“Монголын үндэсний олон нийтийн телевизийн 50 жилийн ой” сэдэвт марк худалдаанд гарлаа.

09 сарын 21



“Хаан банк”-ны харилцагчийн төлбөрийн картыг хэрэглэгчдэд хаягийн дагуу хүргэж эхэллээ.

10 сарын 06



“Монгол улсад мэдээлэл харилцаа холбооны дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэсний 50 жил” сэдэвт марк худалдаанд гарлаа.

10 сарын 12



“Капитал банк”-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, харилцагчийн карт хүргэлтийн ажлыг эхлүүлсэн.

10 сарын 19



“Голомт банк”-тай хамтран, харилцагчдын даатгалийн гэрээ хүргэж эхэллээ.

10 сарын 23



“Төрийн банк”-ны харилцагчийн карт хүргэлтийг ажлыг эхлүүлсэн.

10 сарын 23



Тээвэр зуучийн үйлчилгээний эрх авлаа.

10 сарын 25



Жишиг салбар байгуулав.

10 сарын 25



POST SHOP төслийг эхлүүлэв.

10 сарын 31



Харилцаа үйлчилгээний стандарт, салбарын тохижилт үйлчилгээний стандарт батлагдлаа.

10 сарын 31



Компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ тодорхойлов.

11 сарын 01



Төрийн байгууллагуудын хооронд дамжиж байгаа албан бичгүүдийг өдөрт нь хүргэх зорилгоор А бүсийн хүргэлтийг нэвтрүүлсэн.

11 сарын 15



“Монгол Улсын үндэсний бахархалт бэр цэцэг” сэдэвт шуудангийн марк худалдаанд гарлаа

11 сарын 24



Компанийн хувьцааны үнэ 765,13-д хүрэв.

12 сарын 03



“Торгоны замын зоос” сэдэвт шуудангийн марк худалдаанд гарлаа.

12 сарын 05



Дугтуй үйлдвэрлэх шинэ тоног, төхөөрөмж худалдан авч шинэ загварын дугтуй үйлдвэрлэж эхлэв.

12 сарын 08



“Шинэ жилийн мэнд хүргэе!” сэдэвт шуудангийн марк худалдаанд гарлаа.





МОНГОЛ
ШУУДАН



Улс хоорондын транзит үйлчилгээг шинэ шатанд гаргалаа

✈ АГААРААР

🚂 ТӨМӨР ЗАМААР

🚚 АВТО ЗАМААР



УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Хүний нөөцийн талаар

Тускомпани нь удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийг оновчтой хуваарилж, олон улсын шуудангийн жишигт нийцэхүйц байдлаар орон тоог төлөвлөж, компанийн удирдлагын бүтцийг 2017 оны 01 дүгээр сарын 02-ноос эхлэн, шинэчлэн зохион байгууллаа. Компанийн статус өөрчлөгдсөнтэй холбогдуулан, компанийн эрхэм зорилго, зорилтын хүрээнд “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан ба нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг шинээр байгуулж, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж батлууллаа.

ERP системийг нэвтрүүлж эхэлснээр урьд нь ажилтнуудын бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг Microsoft excel баазын тусламжтайгаар хөтөлж, хүний нөөцтэй холбогдолтой нэгдсэн тайлан гаргах, харьцуулалт, хайлт хийхэд хүндрэлтэй, мэдээллийн найдвартай хадгалалт сул байсныг тодорхой хэмжээнд шийдвэрлэж, хөгжүүлэлт хийн ажиллаж байна.


“Монгол шуудан” ХК-ийн харъяа ШҮ-ний салбар, хэсгүүд болон ажилтнуудыг аттестатчилах үйл ажиллагааг зохион байгуулж, аттестатчиллыг Улаанбаатар хотын хэмжээнд нэгдсэн нэг аргачлалаар 2017 оны 06 сард явуулж дуусгалаа.


Ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нь бидний тулгамдсан асуудлуудын нэг байсан бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн KPI системээр ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, компанийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг шинэ шатанд гаргах, улмаар цахим технологид суурилсан тайлан, мэдээ, судалгаа гаргах, ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, ажлын эмх цэгцийг улам боловсронгуй болгох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар компанийн хэмжээнд шуудангийн үйлчилгээний 39 салбар, 22 аймаг, дүүргийн газар, 331 сумын салбарт нийт 916 хүн ажиллаж байна.









 Улаанбаатар хотод **397**, хөдөө, орон нутагт **519** ажилтнууд ажиллаж байгаагаас үндсэн **881**, гэрээт **35** ажилтан байна.

Хүйсийн хувьд авч үзвэл,

 **70.5%** нь эмэгтэй,
29.5% нь эрэгтэй, боловсролын хувьд,


 магистр **20**,
бакалавр **454**,
тусгай дунд **139**,
бүрэн дунд **256**,
бүрэн бус дунд **43**,
бага боловсролтой **4** ажилтан,

насны хувьд авч үзвэл,

-  24 хүртэлх насны **36**,
-  25-29 хүртэлх **122**,
-  30-34 хүртэлх **152**,
-  35-39 хүртэлх **115**,
-  40-44 хүртэлх **109**,
-  45-49 хүртэлх **181**,
-  50-54 хүртэлх **144**,
-  55-аас дээш насны **50** ажилтан байна.

Хүний нөөцийн статистик үзүүлэлтүүд

 Нийт ажилтнуудын тоо  Хүйсийн харьцуулалт



Хууль, эрх зүйн талаар

Компанитай холбоотой хууль эрх зүйн чиглэлийн бүх асуудлыг цаг тухай бүрт нь шийдвэрлэн, компанийн үйл ажиллагаа, авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлэсэн. Компанийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Ажил үүргийн хуваарийн дагуу 319 аж ахуй нэгж байгууллага, хувь хүнтэй байгуулах гэрээний үндэслэлд хяналт тавин ажиллаж, Монгол Улсын “Шуудангийн тухай хууль”-д өөрчлөлт оруулах саналыг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлээ.

Түүнчлэн “Сонгон шалгаруулалтын журам”, “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний КРІ системийн нэвтрүүлэх журам”, “Аттестатчилал явуулах журам”, “Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам”, “Сургалт явуулах журам”, “Харилцаа-үйлчилгээний стандарт, салбарын тохижилт-үйлчилгээний стандартууд”, “Өргөдөл, гомдлыг бүртгэн шилжүүлэх, шийдвэрлэх журам”, “Цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтын журам”, “Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт”, “Архивын үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам”, “Албан хэрэг хөтлөлтийн журам”-уудыг шинэчлэн боловсруулж, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сургалт, хөгжлийн талаар

Захиргаа, хүний нөөцийн газраас аймгуудын ШҮГ-ын ажилтнуудад “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үнэлж, урамшуулал олгох нь” сэдэвт ОНЛАЙН СУРГАЛТ зохион байгууллаа. Сургалтанд нийт 20 аймгийн ШҮГ-ын 150 ажилтнууд оролцлоо.

Тус компанийн 5 ажилтан Тайланд Улсын Ази номхон далайн болон дэлхийн шуудангийн байгууллагын ажилтнуудын сургалтын төвд “Үйлчилгээний чанарын стандарт”, “Интернет худалдаанд шуудангийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах”, “Эдийн засгийн” сургалт, “Интернет худалдааны менежмент”, Австралийн Сидней хотод Дэлхийн шуудан холбоо, Дэлхийн гаалийн байгууллагуудын хамтран зохион байгуулсан “Гааль-шуудан” сэдэвт гадаадын сургалтуудад хамрагдлаа.



ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ТЕХНОЛОГИЙН ТАСРАЛТГҮЙ ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Шуудангийн солилцооны талаар

Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд орох, гарах чиглэлд улс хоорондын шуудангийн агаарын тээврээр 39.9 мянган ширхэг богц буюу 284.7 кг, газраар 1.3 мянган ширхэг богц буюу 7.8 мянган кг, дотоодын шуудангийн агаарын тээврээр 5.6 мянган ширхэг богц буюу 5.3 мянган кг, зүүн, говь, төв, хангайн аймгуудад хот хоорондын тээврээр 33.9 мянган ширхэг богц буюу 275.1 мянган кг, төмөр замаар 9 мянган ширхэг богц буюу 29.9 мянган кг, өөрийн тээврээр 3.4 мянган ширхэг богц буюу 20.1 мянган кг, Улаанбаатар хотын салбаруудад 70.9 мянган ширхэг богц буюу 372.9 мянган кг шуудан хүлээн авч, ялган боловсруулж гаргасан.




2017 онд нийт бичиг захидал, боодол, илгээлтийн 77% буюу 1192499 ширхэг илгээмжийг хаягт эзэнд нь хяналтын хугацаанд, 21.6% буюу 334593 ширхэгийг сааталтай гардуулж, 1.4% буюу 21609 ширхэг хаягийн зөрчилтэй, гардуулах боломжгүй илгээмжийг илгээгчид нь буцаажээ. гэж нэмэх.

Сааталтай хүргэгдсэн шуудангийн илгээмжийн тоо хэмжээ нь нийт солилцооны **0.18%**-ийг эзэлж байгаа бөгөөд энэ нь бүх нийтийн үйлчилгээний чанарын саатлын үзүүлэлтийн зөвшөөрөгдсөн хэмжээнд байна.

Хэрэглэгчийн үйлчилгээний талаар

Энэ онд “Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төв” нь харилцах утсаар 28,4 мянга, үйлчилгээний заалаар 1.6 мянга, УХШ-ийн лавлагаа 1.4 мянга, сайтны чатаар 1.8 мянга, дотоод сүлжээгээр 775, компанийн фэйсбүүк хуудсаар 74, электрон шуудангаар 56 лавлагаанд хариу өгч ажиллалаа.

Хэрэглэгчийн гомдол, саналд тухай бүр нь дүгнэлт хийж, уг ажлын мөрөөр арга хэмжээ авч, үйлчилгээг сайжруулан ажиллаж байна



Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар



+ 78 улс

Улс хоорондын шуудангийн үйлчилгээний маршрутыг шинэчлэн тогтоож, агаарын тээврийн “Туркиш эйрлайнс” компанитай үнэ тарифын тогтвортой гэрээг байгуулан ажилласнаар тээврийн зардлын өсөлтөөс сэргийлсэн төдийгүй дэлхийн 80 гаруй улсад шуудан илгээх гарцтай боллоо.

Улс хоорондын шуудангийн үнэ тарифын тогтвортой байдлыг хадгалан, “Хэрэглэгчдэд ээлтэй” үйлчилгээг үзүүлсээр ирлээ.

Шуудангийн илгээмжийн ялган боловсруулах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор гибрид шуудангийн дугтуйлагч машин-1 ширхэг, өдөрлөгч машин-1 ширхэг, хүргэгчийн гар ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор ухаалаг гар утас 20 ширхэгийг шинээр ашиглалтанд орууллаа.



Тээвэр зууч, логистикийн ажлын хүрээнд

Компанийн стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн, логистик, ачаа тээврийн салбарт ашигт үйл ажиллагааг явуулах зорилгоор гадаад, дотоод ачаа, шуудан тээвэр, тээвэр зууч-логистикийн үндсэн үйлчилгээ болох шинэ үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа.

Транзит шуудангийн үйл ажиллагааг сайжруулах, шинээр суваг нээх талаар

Транзит шуудангийн үйл ажиллагаа 2016 онд эхэлсэн боловч гадаад харилцагч байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор 2017 оны 08 дугаар сараас хойш бүрэн зогссон. Гэвч яаралтай арга хэмжээ авсны үр дүнд шинээр харилцагч нэмж, транзит шуудангийн тээврийн сувгийг **агаар болон төмөр зам, автозамаар** нээлээ. 2017 оны 10 дугаар сараас эхлэн шинэ сувгуудаар тээвэр хийгдэж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар төмөр замаар 1 удаа, бойнг 757 ачааны онгоцоор нийт 8 удаа, автозамаар нийт 34 удаагийн тээвэр хийж гүйцэтгэсэн.

Мөн компанийн эзэмшлийн HD120, HD700 машинуудад гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн эрх авах, хилээр орж, гарах эрхийг баталгаажуулснаар цаашид шаардлагатай болон яаралтай тохиолдолд өөрийн тээврийн хэрэгслээр хил дамнан тээвэрлэлтийг хийх боломжтой боллоо.



Дотоодын логистикийн үйлчилгээг өргөжүүлэх талаар

Замын-Үүд—Улаанбаатар—Замын-Үүдийн чиглэлийн логистик тээврийн хэмжээ, рэйсийн давтамж, орлогыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтайгаар хийсний үр дүнд зөвхөн Замын-Үүдийн логистикийн үйлчилгээний жилийн орлого нь 484.1 сая төгрөгт хүрсэн. Орлого нэмэгдүүлэх гол ажлын нэг нь өөрийн тээврийн хэрэгслээр алдагдалтай тээвэр хийж байсныг зогсоож, гаднаас том оврын тээврийн хэрэгслийг түрээслэн, тээвэрлэлтэнд явуулсан нь гол нөлөө үзүүлсэн.

2013-2016

HD120
Эзэлхүүн: 20м³
Даац: 8-10тн



2017

HD700, VOLVO TIR
Эзэлхүүн: 80м³ ▲ 4 дахин
Даац: 40тн ▲ 4 дахин

Өмнө

+ 8м-ээр урт болсон



Орон нутгийн тээшийн үйлчилгээ



Логистикийн үйлчилгээний хүрээнд хийгдсэн гол ажлуудын нэг нь Авто тээврийн үндэсний төвтэй хамтран, зорчигч тээврийн төвийн зорчигчийн болон дайвар ачааг хадгалах, илгээх “Орон нутгийн тээшийн үйлчилгээ”-г 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр шинээр нэвтрүүлсэн явдал юм.

Цаашид бид бүх аймгуудын АТҮТ-ийн харьяа зорчигч тээврийн төв дээр ачаа тээш хүлээн авах, хадгалах, илгээх цэгийг байгуулахаар шийдвэрлэж, одоогийн байдлаар Дархан-Уул, Орхон, Говь-Алтай, Өмнөговь аймгуудад нээгээд байна.

Улс хоорондын илгээлт, карго үйлчилгээг эхлүүлэх талаар



Улс хоорондын илгээлт, карго үйлчилгээг эхлүүлэх талаар БНСУ, АНУ, Япон зэрэг улсуудыг судалж, карго үйлчилгээ эхлүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд судалгаануудыг хийж байна.

Улс хоорондын тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд цаашид төмөр зам болон агаарын тээврийн компанитай гэрээ байгуулсанаар тээвэр зуучийн үйл ажиллагаа явуулах бүх нөхцөл бүрдэх юм. Энэхүү зөвшөөрөл нь гадаадын компаниудтай хамтарч ажиллахад логистикийн үйл ажиллагаа явуулах эрхтэй гэдгийн баталгаа болох юм.

Хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагааны талаар

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, Сангийн сайдын баталсан тендер шалгаруулалтын жишиг бичиг, баримтын дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас худалдан авах ажиллагааны үйл явцыг хурдан, шуурхай олон нийтэд хүртээлтэй, ил тод, нээлттэй зохион байгуулж, “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-ийг ашиглан, www.tender.mn сайтад 2017 онд тус компанид хэрэгжүүлж буй төсөл

хөтөлбөрүүдийн мэдээллийг цаг тухай бүрт нь бүртгүүлэн байршуулж байна.

Мөн шилэн дансны хуулийг дагаж мөрдөн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, Сангийн яамны www.shilendans.gov.mn сайтад мэдээллийг сар, улирал бүр байршуулсан.

“Монгол Шуудан” ХК нь өөрийн хөрөнгөөр **7,1 тэрбум** төгрөгийн **58** хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, үүнээс **2,5 тэрбум** төгрөгийн их засвар, бараа худалдан авах ажлыг гүйцэтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт шалгалтын талаар

“Монгол шуудан” ХК нь тайлант хугацаанд санхүүгийн бүртгэлийн системд технологийн шинэчлэл хийж, ПОСЫН СИСТЕМ нэвтрүүлээ.

“Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/101 тоот тушаалаар компанийн бараа бүтээгдэхүүнийг бар коджуулах борлуулалтын системийг судалж, балансад бүртгэлтэй **280** нэр төрлийн **бараа, үнэт цаас, 1928** нэр төрлийн **сери, задгай, тамгатай маркийг** баркоджууллаа.




Авлага барагдуулах аян


“Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/169 тоот тушаалын дагуу 2017 оны II улирлын санхүүгийн тайланд тусгагдсан авлагыг барагдуулах 2 сарын аяныг зохион байгуулж, санхүүгийн тайланд тусгагдсан нийт авлагын **1,142.4 сая** төгрөгийн авлагыг барагдуулсан нь нийт авлагын **37.63%**-ийг эзэлж байна.

2017 оны III улиралд компанийн нийт авлага **412.5 сая** төгрөгөөр буурсан. Авлага барагдуулалтыг аймаг болон Улаанбаатар хотоор нь салгаж, графикаар харуулбал:

Аймгийн авлага барагдуулалт



Улаанбаатар хотын авлага



 2017.06.30

 2017.09.30

Дээрх авлага бууруулах 2 сарын аяны ажлын тайланг 2017 оны 10 сарын өдрийн захирлын зөвлөлийн хуралд танилцуулж, авлагын аянг үргэлжлүүлэх тухай албан даалгавар гарч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

РИ-БРЕНДИНГ

ШУУДАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭГ СУРТАЛЧЛАХ
ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ,
ШИНЭЭР НЭВТРҮҮЛЭХ



КОМПАНИЙН ӨНГӨ ТӨРХИЙГ ШИНЭЧЛЭХ, БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭГ СУРТАЛЧЛАХ, ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ


Монгол Шуудан ХХК нь 2017 оноос Ри-брендингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Компанийн зүгээс маркетингийн хүрээнд хийгдэх хамгийн томоохон ажлын нэг болох компанийн өнгө төрхийг шинэчилж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан тохилог найрсаг орчинд шуудангийн үйлчилгээг үзүүлэх ребрендинг хийх явдал юм. Энэхүү ажлын хүрээнд компанийн алсын хараа, өнгө төрхийг илэрхийлсэн, үйлчлүүлэгчдийн сэтгэлийг татах, дотно сэтгэгдэл төрүүлэхүйц шинэ логог баталж, түүнтэй уялдуулан, шуудангийн

үйл ажиллагаатай холбоотой бүх материал, хэрэглэгдэхүүний нэгдсэн стандарт бүхий брэндбүүк гаргасан.

Компанийн түгээмэл мэргэжлийн ажилтнуудын хувцасны загварыг шинэ өнгө төрхтэйгээр гаргаж, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан, 2018 онд нийт ажилтнуудыг дүрэмт хувцсаар хангахаар зорин ажиллаж байна. Түүнээс гадна тээврийн хэрэгслийн өнгө төрхийг шуудангийн онцлогт тохируулан шинэчиллээ.

Бэлгэдлийн илэрхийлэл



Жишиг салбар

Логоны өнгөний код


C 0 **R 240** PANTONE 485 C
M 100 **G 0**
Y 100 **B 0**
K 0




C 0 **R 255** PANTONE Trance.White
M 0 **G 255**
Y 0 **B 255**
K 0


Шуудангийн ажилтны харилцаа, үйлчилгээний стандарт болон салбарын тохижилт үйлчилгээний стандартыг шинээр боловсрууллаа.

Шуудангийн үйлчилгээний салбарын шинэ өнгө төрх, тохижилт болон ая тухтай үйлчлүүлэх орчинг бүрдүүлсэн “Жишиг салбар”-аар хамгийн байршил сайтай, үйлчлүүлэгчдийн цар хүрээний хувьд тохиромжтой 46-р салбарыг сонгон авч, 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр нээлтээ хийлээ.

Тухайн жишиг салбарт үйлчилгээний стандартад нийцсэн үйлчилгээг бүрэн төгс хийж чадахуйц ажилтнуудыг сонгон шалгаруулж, тэднийг мэргэшүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан ба сургалтаар олж авсан мэдлэгээ улам бататгаж, чиг хандлагаа өөрчлөх, үйлчилгээний төгс стандартыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.



САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын
2015 оны 70 дугаар тогтоол,

Засгийн газрын 2015 оны 330
дугаар тогтоолын дагуу

“Монгол шуудан” ТӨХК-ийн
нийт хувьцааны

 **34%** буюу
33,859,363 ширхэг

энгийн хувьцааг
2016 оны нэгдүгээр сарын
8-ны өдөр Монголын
Хөрөнгийн биржээр
дамжуулан арилжиж

6,263,982,155

төгрөгийг 256 хувьцаа
эзэмшигчээс татан
төвлөрүүлсэн байна.


Компаний үнэлгээ
оны эцсийн байдлаар

55.02 ТЭРБУМ ₮

Хувьцааны хоёрдогч зах зээл дээрх арилжаа 2017 онд нийт 205 өдрийн арилжаанд идэвхитэй байж, 2017 оны нэгдүгээр сарын 2-ны өдөр **330** төгрөгийн нээлтийн ханштайгаар эхэлж, 2017 оны 11 дүгээр сарын 24-ний **▲ 765.13** төгрөгт хүрч **түүхэн дээд үнээ шинэчлэн тогтоосон** байна.

2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар тус компаний хувьцаа **552.5** төгрөгийн ханштай байна. Хувьцааны ханш **анхны нэрлэсэн ханш** болох **185** төгрөгөөс буюу хувьцаа эзэмшигчдийн анхны хөрөнгө оруулалтаас **▲ 2.98 дахин** өсөөд байна. Компаний Хөрөнгийн бирж дээрх **үнэлгээ 32.8 тэрбум** төгрөгөөс оны эцсийн байдлаар **▲ 55.02 тэрбум** төгрөгт хүрээд байна. Өнгөрсөн 2017 онд компаний хувьцааны ханшийн хэлбэлзлийг (хаалтын ханш) харвал:

Хувьцааны үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол шуудан ХК-ний нэгж хувьцааны **дээд үнэ 2016 онд 342.76** төгрөг байсан бол **2017 онд 765.13** төгрөгт хүрсэн байна.

Өнгөрсөн 2017 оны эхний 9 сарын байдлаар **315-аас 400** төгрөгийн хооронд тогтвортой байсан **хувьцааны үнэ** IV улирлаас буюу тухайн оны 10 дугаараас сараас эхлэн 11 дүгээр сарын сүүл үе хүртэл огцом ▲ өсөлтийг үзүүлсэн байна.

Арилжааны **тоо ширхэгийн хувьд өдөрт дунджаар 13,128 ширхэг** арилжаалагдсан байгаа нь өдөрт ойролцоогоор **5.6 сая** төгрөгийн, жилдээ **1.15 тэрбум** төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээл дээр хийжээ.

Ногдол ашиг


Тус компаний нэгж хувьцааны өгөөж /EPS/ нь **12.3** төгрөг бөгөөд компаний хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, ногдол ашиг хуваарилсны дараах төлбөрийн чадварыг харгалзан 2018 оны гуравдугаар сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №18/04 тоот тогтоолоор нэгж хувьцаанд **3.68** төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан.

Үзүүлэлт	2016 он	2017 он
Цэвэр ашиг /төг/	1,006,584,568.16	1,224,156,778.18
Нийт хувьцааны тоо	99,586,363	99,586,363
Нэгж хувьцааны үнэ /төг/	339.86	552.50
Нэгж хувьцааны өгөөж /EPS/	10.1 төг	12.3 төг
Нэгж хувьцааны дансны үнэ	206.0	215.0
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	0.0359	0.0300
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/	0.0491	0.0572
Нийт хөрөнгийн эргэц /ROTA/	0.0385	0.0331

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2017 оны эцсийн байдлаар Компаний нийт хувьцааны 66 хувийг Төр, 28.34 хувийг Ард Санхүүгийн Нэгдэл, 5.66 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.



2017 оны хөрөнгө оруулалт

“Монгол Шуудан” ХК нь өөрийн хөрөнгөөр 7,1 тэрбум төгрөгийн 58 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, үүнээс 2,5 тэрбум төгрөгийн их засвар, бараа худалдан авах ажлыг гүйцэтгэсэн байна.

Аудитын тайлан

ТҮЗ-ийн Аудитын хяналтын хорооноос тус компанийн 2017 оны санхүүгийн тайлан балансад аудит хийх компаниар “Мэжик консалтинг” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулж ажилласан. 2017 оны санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд аудит хийж “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт гаргасан.

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2017 онд жилийн эцсийн нийт орлого **13,672.6 сая** төгрөгт хүрч, 2016 оноос **14.6** хувиар өссөн байна. 2016 онд шинээр нэвтэрсэн хил дамнасан и-худалдааны хүргэлтийн үйлчилгээний орлого 1,531.0 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлого /хүүгийн орлого/ 1,450.6 сая төгрөгийн орлого нь энэхүү өсөлтийг бий болгоход голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын эдийн засгийн хувьд тодорхойгүй байдал зонхилсон 2016 онд үүссэн хүндрэлээс гарах шилжилтийн үе байсан ч шуудангийн үндсэн үйлчилгээг иргэн бүрт хүргэх үүргээ биелүүлж ашгийн хэмжээгээ нэмэгдүүлж ажиллалаа.

2016 онд компани 1,006.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2017 онд **1,224.1 сая** төгрөгийн ашигтай ажиллаж, цэвэр ашиг урьд оныхтой харьцуулахад **21.6** хувиар өссөн.

Компаний зардлын өсөлт **13.6** хувиар нэмэгдсэнд гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй зардал өссөн нь нөлөөлсөн байна.

Орлого, үр дүн _сая.төг

Үзүүлэлт	2015	2016	2017	Өсөлт
Орлого	10,094.18	11,923.09	13,672.64	14.7%
Зардал	9,976.87	10,843.01	12,321.04	13.6%
Нийт ашиг	117.31	1,080.08	1,351.60	25.1%
Орлогын албан татвар	23.30	73.49	127.43	73.4%
Цэвэр ашиг	94.01	1,006.58	1,224.16	21.6%

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2017 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ сая.төг

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он		2017 төл. 2016 төл	Харьцуулсан хувь, зөрүү 2017 гүйц. 2016 гүй.
	гүйцэтгэл	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл		
Үнэт /марк, дугуй/	985.9	935.4	1,000.0	983.2	95%	105%
Шуудангийн үйлчилгээ /захидал, боодол, илгээлт/	5,061.8	4,976.6	6,050.0	6,155.8	93%	124%
Нийт орлого	10,094.1	11,923.1	13,070.0	13,672.6	104%	115%
Нийт зардал	9,976.8	10,843.1	12,355.0	12,321.0	106%	114%
Үүнээс удирдлагын	501.6	582.1	820.0	700.6	137%	120%
Татварын өмнөх ашиг	117.3	1,080.0	715.0	1,351.9	77%	125%
Орлогын татвар	23.3	73.4	71.5	127.4	77%	174%
Цэвэр ашиг	94.0	1,006.6	643.5	1,224.1	77%	122%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	0.99	0.91	0.95	0.91	102%	100%
Нийт ажиллагсад	905	912	920	916	99%	100%
Цалингийн сан	4,703.2	5,418.5	6,400.0	6,419.7	119%	118%
Нийт авлага	2,734.1	3,130.8	3,000.0	3,533.4	100%	113%
Нийт өр төлбөр	1,138.5	7,550.5	2,000.0	19,435.1	100%	257%
Хөрөнгө оруулалт	413.7	433.9	6,990.2	2,488.4	618.2%	573%
Үүнээс: Өөрийн хөрөнгөөр	413.7	433.9	6,990.2	2,488.4	618.2%	573%
Ногдол ашиг	28.2	301.8		273.5	-	91%
Элэгдлийн зардал	702.8	696.6	650.0	807.1	93%	116%
Валютын ханшийн ашиг/алд	10.0	28.1		(299.3)	-	-
Хөдөлмөр хамгааллын зардал	12.1	14.4	75.0	10.3	163%	72%


“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус компаний нийт активын хэмжээ 2017 онд **40,852.25 сая** төгрөгт хүрч урьд оныхоос **45.6** хувиар өссөн байна. Уг өсөлтөнд компаний 2016 онд эхлүүлсэн БНХАУ-аас ОХУ руу чиглэсэн транзит үйлчилгээний орлого ихэсч эргэлтийн хөрөнгийг 63.8 хувиар өсгөсөн нь гол түлхэц болсон байна.

Нийт хөрөнгө _сая.төг


Үзүүлэлт	2015	2016	2017	Төгрөг	Өөрчлөлт Хувь
Нийт хөрөнгө	15,295.90	28,059.00	40,852.25	12,793.25	45.6%
Эргэлтийн хөрөнгө	6,740.70	19,749.90	32,355.63	12,605.73	63.8%
Эргэлтийн бус хөрөнгө	8,555.20	8,309.10	8,496.62	187.52	2.3%

Компаний эргэлтийн хөрөнгө 2016 онд нийт хөрөнгийн 70.4 хувийг эзэлж байсан бол 2017 онд хувийг 79.2 хувийг эзэлж, компаний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нэмэгдлээ.




САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт солилцоо




Улс хоорондын нийт солилцоо




Улс хоорондын нийт солилцоо 2017 онд өмнөх жилээс **0.01** хувиар өссөн.

Улс хоорондын солилцоо




- Улс хооронд гарах солилцоо 2017 онд өмнөх жилээс **-11.12** хувиар агшсан.
- Улс хооронд орох солилцоо 2017 онд өмнөх жилээс **10.74** хувиар өссөн.

Дотоод нийт солилцоо



Дотоод нийт солилцоо 2017 онд өмнөх жилээс **16,84** хувиар өссөн.

Дотоодын солилцоо



- Дотоод **боодлын солилцоо** 2017 онд өмнөх жилээс **61.29** хувиар өссөн.
- Дотоод **илгээлтийн солилцоо** 2017 онд өмнөх жилээс **2.97** хувиар өссөн.
- Дотоод **бичиг захидлын** солилцоо 2017 онд өмнөх жилээс **6,91** хувиар өссөн.

ШУУДАНГИЙН САЛБАРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын шуудангийн салбарын хууль эрх зүйн болон тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) хариуцдаг. Түүнчлэн шуудангийн салбарт үйлчилгээ эрхлэгчдэд “Шуудангийн сүлжээ байгуулах”, “Шуудангийн сүлжээг ашиглах, үйлчилгээ эрхлэх” гэсэн хоёр үндсэн ангиллаар тусгай зөвшөөрлийг олгодог. Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хуулиар

“ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭ ГЭДЭГ нь ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН САЛБАР, ЦЭГҮҮД, ТЭДГЭЭРИЙН ХООРОНД ШУУДАНГИЙН ИЛГЭЭМЖ ТЭЭВЭРЛЭХ ЧИГЛЭЛИЙН НИЙЛБЭР ЦОГЦ ЮМ” хэмээн тодорхойлсон байдаг.


Энэ хуулийн заалтын дагуу ХХЗХ-ноос шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах “А” ангиллын тусгай зөвшөөрлийг олгож байна. Уг сүлжээгээр Шуудангийн тухай хуулийн 3.1.3-3.1.6-д заасан илгээмжүүдийг явуулагчаас хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэн дамжуулах, хаягт эзэнд нь хүргэх үйлчилгээ явагдах бөгөөд хэрэглэгчдэд үйлчлэх үйлчилгээний “Б” ангиллын тусгай зөвшөөрлийг ч мөн ХХЗХ-ноос тодорхой нөхцөл шаардлагын дагуу олгодог.

Шуудангийн салбар нь мэдээлэл харилцаа холбооны салбарт харьяалагддаг бөгөөд тухайн салбарынхаа 2 хүрэхгүй хувийн орлогыг бүрдүүлж байна.

Эх сурвалж: Харилцаа Холбооны Зохицуулах Хороо

Шуудангийн үйлчилгээний солилцооны үзүүлэлтүүдийн харьцуулалт

Буухиа шуудангийн солилцоо_2015.06.30 - 2017.06.30




ЗАХ ЗЭЭЛ

Шуудангийн үйлчилгээний солилцооны үзүүлэлтүүдийн харьцуулалт

2017.06.30


Шуудангийн илгээлт, боодлын солилцооны харьцуулсан үзүүлэлт /ГАРАХ/ 2015.06.30 - 2017.06.30



Шуудангийн үйлчилгээний солилцооны үзүүлэлтүүдийн харьцуулалт

2017.06.30


Шуудангийн илгээлт, боодлын солилцооны харьцуулсан үзүүлэлт /ОРОХ/ 2015.06.30 - 2017.06.30



Эдийн засгийн үзүүлэлтүүд

2017.06.30


Мэдээлэл, харилцаа холбооны салбарын НИЙТ ОРЛОГО_тэрбум төг



Эдийн засгийн үзүүлэлтүүд

2017.06.30


Мэдээлэл, харилцаа холбооны салбарын НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ_тэрбум төг



Эдийн засгийн үзүүлэлтүүд

2017.06.30

Мэдээлэл, харилцаа холбооны төсөвт ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО_тэрбум төг



“Монгол шуудан” ХК-ийн дотоодын ба улс хоорондын шуудангийн зах зээлд эзлэх хувь



2016 оны эцсийн байдлаар “Монгол шуудан” ХК нь тухайн жилд шуудангийн салбарын нийт орлогын 69.7%-ийг бүрдүүлсэн байв. Түүнчлэн дотоод шуудангийн орлогын 82%, харин улс хоорондын шуудангийн ердөө 26%-ийг тус тус бүрдүүлжээ.

Өнөөдөр дэлхийн шуудангийн оператор компаниуд эдийн засгийн хүнд нөхцөл, салбар доторх ширүүн өрсөлдөөн, орчин үеийн цахим давалгаа зэрэг томоохон сорилтуудтай нүүр тулж байна. Цахим орчны нөлөөгөөр бичиг захидлын солилцоо буурч байгаа ч и-худалдааны өсөлтөөр оператор компаниудын орлого өсч байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН



ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тус компани нь 2016 оны "ТОП-100" аж ахуйн нэгжийн 77-д жагсаж, энэхүү нэр хүндтэй шагналыг **10** дахь удаагаа хүртлээ.

Харилцаа, холбоо, мэдээллийн технологи үүсч хөгжсөний 96 жилийн ойг тохиолдуулан, "Хөдөлмөрийн хүндэт медаль" - **1**,

"Хүндэт холбоочин" цол тэмдгээр **2**,

" Шуудангийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр **17**,

"Хүндэт жуух" **23**,

МЗХ-ны шагналаар **1**,

компанийн шагналаар **42** ажилтанг тус тус шагнаж урамшуулжээ.



ОЛОЛТ АМЖИЛТ

Буухиа шууданг **116** улстай солилцож эхлэв.

"Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага 2017" өдөрлөгт амжилттай оролцож, тус өдөрлөгийн **шилдэг байгууллагаар** шалгарлаа.

"Монголын Топ-100 аж ахуйн нэгж"-ийн нэгээр шалгарав.

"Хөрөнгө оруулагч үндэстэн" чуулга уулзалтанд амжилттай оролцож **TURNAROUND OF THE YEAR** шагнал хүртлээ.

Харилцаа Холбооны салбарын СПОРТ наадамд амжилттай оролцож байгууллагын дүнгээр **мөнгөн цом** авлаа.

Компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ тодорхойлов.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн ажилтнуудын орон сууц худалдан авах, орон сууцны нөхцлөө сайжруулах, хувийн орон сууц барих болон орон сууцны зээлээ төлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын амжилт гаргасан, цаашид тогтвор суурьшилтай ажилласан **20** ажилтанд нийт **100 сая** төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлсэн.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, захиргаа ҮЭХ-ны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-г өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, ажилтны ар гэрт нь хагацал тохиолдсон **4**, ойр дотных нь хүн нас барсан **21**, ар гэр нь болон өөрөө хүндээр өвдсөн **5**, гэнэтийн гамшиг осол тохиолдсон **2** ажилтанд буцалтгүй тусламж, компанийн хоорондоо гэр бүл болсон **2** хосод, өрх толгойлсон **32** ажилтанд түлээ нүүрс, унааны хөнгөлөлт, эх үрсийн баярыг тохиолдуулан **0-16** хүртэлх насны **303** хүүхдэд баярын бэлэг гардуулан тусламж, тэтгэмж, дэмжлэгийг үзүүллээ.

МШХХТГ-ын даргын “Ахмад настны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2009 оны 04-р сарын 13-ны өдрийн 1/210 тоот зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, компанийн ахмад настууд, ажиллаж байгаа болон өндөр насны тэтгэвэрт гарсан “**Хүндэт холбоочин**”-д **9.6 сая** төгрөгийн нэмэгдэл тэтгэмжийг олгосон ба компанийн ахмад настуудын биеийн байдал, ахуй амьдралын асуудлаар холбогдох хүмүүсээс байнга мэдээлэл авч, хүнд өвчнөөр өвдөж, хүний асаргаанд орсон **6** ахмадыг эргэж, **600.0 мянган** төгрөгийн буцалтгүй тусламж, нас барсан **7** ахмад настанд **700.0 мянган** төгрөгийн тэтгэмж олголоо.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-нээр эцэслэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан “Монгол шуудан” ХК-ийн санхүүгийн тайланд Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу аудит хийж гүйцэтгэв.

Түүнчлэн бид “Монгол шуудан” ХК-иас хараат бус бөгөөд Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл /НБЁЗОУСЗ/-ийн дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ажилласан болно. Бидний үзэж байгаагаар тус компанийн тайлан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, шударга бөгөөд материаллаг хэмжээний буруу илэрхийлэл агуулаагүй байна.

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант үе: 2017-01-01/2017-12-31_төгрөг

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
ХӨРӨНГӨ	0	0
Эргэлтийн хөрөнгө	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,681,410,953.03	26,659,316,320.01
Дансны авлага	3,134,375,038.38	2,791,724,588.39
Татвар, НДШ – ийн авлага	3,737,198.37	316,093.06
Бусад авлага	77,817,315.86	741,438,699.23
Бусад санхүүгийн хөрөнгө	6,100,000,000.00	350,000,000.00
Бараа материал	1,668,090,777.47	1,723,046,229.79
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	84,451,547.28	89,788,837.99
Бусад эргэлтийн хөрөнгө	0	0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0	0
Эргэлтийн хөрөнгийн дүн	19,749,882,830.39	32,355,630,768.48
Эргэлтийн бус хөрөнгө	0	0
Үндсэн хөрөнгө	8,044,913,203.14	8,165,804,273.31
Биет бус хөрөнгө	263,639,817.87	330,310,766.78
Биологийн хөрөнгө	0	0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0	0
Хойшлогдсон татварын хөрөнгө	0	0
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0	0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0	0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,309,053,021.01	8,496,615,040.08
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	28,058,935,851.40	40,852,245,808.57

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	0	0
Өр төлбөр	0	0
Богино хугацаат өр төлбөр	0	0
Дансны өглөг	6,995,178,353.04	18,315,301,608.08
Цалингийн өглөг	174,422.23	442,279.64
Татварын өр	79,283,217.69	116,473,223.76
НДШ - ийн өглөг	1,676,527.75	10,546,707.79
Богино хугацаат зээл	0	0
Хүүний өглөг	0	0
Ногдол ашгийн өглөг	0	0
Урьдчилж орсон орлого	323,656,719.04	848,689,798.32
Нөөц /өр төлбөр/	0	0
Бусад богино хугацаат өр төлбөр	150,580,631.12	143,725,802.28
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	0	0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,550,549,870.87	19,435,179,419.86
Урт хугацаат өр төлбөр	0	0
Урт хугацаат зээл	0	0
Нөөц /өр төлбөр/	0	0
Урт хугацаат бондын өглөг	0	0
Хойшлогдсон татварын өр	0	0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0	0
Нийт өр төлбөрийн дүн	7,550,549,870.87	19,435,179,419.86
Эздийн өмч	0	0
Өмч: - төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
- хувийн	0	3,385,936,300.00
- хувьцаат	0	-
Халаасны хувьцаа	0	-
Нэмж төлөгдсөн капитал	0	2,538,512,210.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
Эздийн өмчийн бусад хэсэг	8,634,555,470.18	2,710,106,959.73
Хуримтлагдсан ашиг	1,921,210,986.50	2,829,891,394.68
Эздийн өмчийн дүн	20,508,385,980.53	21,417,066,388.71
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	28,058,935,851.40	40,852,245,808.57

Аудит хийсэн санхүүгийн орлого үр дүнгийн тайлан

Тайлант үе: 2017-01-01/2017-12-31_төгрөг

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
Борлуулалтын орлого (Цэвэр)	10,878,878,323.75	12,116,604,477.20
Борлуулалтын өртөг	10,089,639,261.43	11,150,358,677.41
Нийт ашиг (алдагдал)	789,239,062.32	966,245,799.79
Түрээсийн орлого	-	101,000,000.00
Хүүний орлого	527,922,093.73	1,450,619,977.71
Ногдол ашгийн орлого	-	0
Эрхийн шимтгэлийн орлого	-	0
Бусад орлого	-	0
Борлуулалт маркетингийн зардал	-	0
Ерөнхий ба удирдлагын зардал	582,191,391.84	700,682,373.39
Санхүүгийн зардал	-	0
Бусад зардал	-171,185,639.65	-169,359,316
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	516,297,420.02	-299,328,330.11
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	3,093,385.43
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	0
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	0
Бусад ашиг (алдагдал)	-	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,080,081,544.58	1,351,589,143.15
Орлогын татварын зардал	73,496,976.42	127,432,364.97
Татварын дараах ашиг (алдагдал)	1,006,584,568.16	1,224,156,778.18
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,006,584,568.16	1,224,156,778.18
Бусад дэлгэрэнгүй орлого	-	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	0
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	0
Бусад олз гарз	-	0
Орлогын нийт дүн	-	0
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	1,006,584,568.16	1,224,156,778.18

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант үе: 2017-01-01/2017-12-31_төгрөг

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	30,442,243,003.02	51,837,355,502.17
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	14,643,636,062.33	11,319,362,827.26
Эрхийн шимтгэл, хүлээн авсан мөнгө	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,832,068.62	78,217,316.45
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	2,578,919,052.33	3,168,063,448.94
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	13,210,855,819.74	37,271,711,909.52
Мөнгөн зарлагын дүн (-)	23,903,261,459.36	38,766,556,000.67
Ажиллагчдад төлсөн	4,631,975,736.41	5,311,806,780.42
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,063,411,901.85	1,236,350,390.68
Бараа материал худалдан авахад төлсөн	1,033,371,489.89	1,337,472,506.90
Ашиглалтын зардалд төлсөн	1,476,501,830.54	1,696,531,086.10
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	671,794,106.23	733,484,374.92
Татварын байгууллагад төлсөн	687,239,002.83	1,000,226,694.72
Даатгалын төлбөрт төлсөн	30,875,620.06	39,380,686.45
ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	14,308,091,771.55	27,411,303,480.48
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,538,981,543.66	13,070,799,501.50
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	527,921,677.53	7,266,090,374.95
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	4,850,000.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	666,800.00
Хүлээн авсан хүүний орлого	527,921,677.53	1,160,573,574.95
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
ХО бусад мөнгөн орлого	-	6,100,000,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	6,882,783,707.00	1,247,082,107.88
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	416,204,884.00	805,383,107.88
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	89,685,500.00	91,699,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	6,100,000,000.00	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-

▶ Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант үе: 2017-01-01/2017-12-31_төгрөг

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
Буцаан олгосон зээл болон урьдчилгаа	-	
ХО бусад мөнгөн зарлага	276,893,323.00	350,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,354,862,029.47)	6,019,008,267.07
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	
Мөнгөн орлогын дүн (+)	6,652,798,180.43	
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,201,341,833.45	
Төрөл бүрийн хандив	-	
СҮА-ны бусад мөнгөн орлого	451,456,346.98	
Мөнгөн зарлагын дүн (-)	40,309,226.38	303,855,696.56
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	
Төлсөн ногдол ашиг	28,203,270.00	291,705,696.56
СҮА-ны бусад мөнгөн зарлага	12,105,956.38	12,150,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,612,488,954.05	(303,855,696.56)
Валютын ханшийн зөрүү	(300,000.00)	(808,046,705.03)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,796,308,468.24	17,977,905,366.98
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,885,102,484.79	8,681,410,953.03
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,681,410,953.03	26,659,316,320.01


Аудит хийсэн цэвэр өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант үе: 2017-01-01/2017-12-31_төгрөг

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,572,700,000.00	0	3,379,919,523.85	2,715,469,027.22	965,329,688.34	13,633,418,239.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0
Залруулсан үлдэгдэл	6,572,700,000.00	0	3,379,919,523.85	2,715,469,027.22	965,329,688.34	13,633,418,239.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	1,006,584,568.16	1,006,584,568.16
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0
Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	(50,703,270.00)	(50,703,270.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	5,919,086,442.96		5,919,086,442.96
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,572,700,000.00	0	3,379,919,523.85	8,634,555,470.18	1,921,210,986.50	20,508,385,980.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	3,385,936,300.00	2 538 512 210,00	0	-5,924,448,510.00	(13,500,000.00)	-13,500,000.00
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	2 538 512 210,00	3,379,919,523.85	2,710,106,960.18	1,907,710,986.50	20,494,885,980.53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	1,224,156,778.18	1,224,156,778.18
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0
Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	-	-
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	(301,976,370.00)	(301,976,370.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0
2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	9,958,636,300.00	2 538 512 210,00	3,379,919,523.85	2,710,106,960.18	2,829,891,394.68	21,417,066,388.71



МАРКИЙН МУЗЕЙ



“МОНГОЛ ШУУДАН” ХК

Сүхбаатарын талбай-9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х-1106, Улаанбаатар-15160, Монгол улс

+(976) 1800-1613

info@mongolpost.mn

www.mongolpost.mn

